



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/42

Номгон

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/96 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Гэгээншавь багийн иргэн Цэдэвсүрэнгийн Ёндонг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг дэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний "Батгэрэлт ирээдүй ТББ"-ын асрамжийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, хүлээлгэн өгөхийг Нийгмийн хамгаалал, хүн ам зүйн асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Сувданцэцэг), Гэгээншавь багийн Нийгмийн ажилтан (Г.Нямдаваа) нарт үүрэг болгосугай.

2.Шаардагдах 500.000 (Таван зуун мянга)-н төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагч (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА   Г. ӨНХБАЯР